

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/09/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН УС, ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН
2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Т.Хүрэлбаатар

Утас: 70272248 Цахим хаяг: khurelbaatart@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
3. Аудитын тайлан	13
3.1 Ерөнхий зүйл	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Материаллаг байдал.....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал.....	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
4. Аудитын илрүүлэлт.....	18
4.1 Залруулсан алдаа.....	18
4.3 Албан шаардлага.....	19
4.4 Зөвлөмж	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100 Зуунмод, Төв аймаг
Утас: 70272248, Факс: 70272582, Имэйл: tuv@audit.gov.mn

2022.02.24 № 01/49
танай -ны № -т

ТӨВ АЙМГИЙН УС, ЦАГ УУР ОРЧНЫ
ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Э.ГЭРЭЛЦОГТ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Ус, Цаг уур орчны шинжилгээний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Ус, Цаг уур орчны шинжилгээний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

19020224

D 2022/2022 он/ALBAN BICHIG

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,038,215,755.67</u>	<u>1,025,352,129.81</u>
33	АВЛАГА	-	240,000.00
33200	Төлбөргэй үйлчилгээний авлага	-	240,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,038,215,755.67	1,025,112,129.81
351	Түүхий эд материал	1,000,462,054.18	987,642,736.83
35110	Тусгай зориулалттай материал	1,000,462,054.18	987,642,736.83
354	Хангамжийн материал	37,753,701.49	37,469,392.98
35410	Бичиг хэргийн материал	1,637,925.10	1,732,369.08
35420	Аж ахуйн материал	3,490,695.00	3,499,898.29
35430	Сэлбэг хэрэгсэл	12,265,111.40	12,806,543.20
35440	Түлш, шатах тослох материал	1,915,000.00	1,029,340.00
35470	Бусад хангамжийн материал	18,444,969.99	18,401,242.41
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,287,759,955.79</u>	<u>1,334,278,802.63</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,287,759,955.79	1,334,278,802.63
392	Биет хөрөнгө	279,235,539.15	324,985,302.66
39201	Барилга, байгууламж, орон сууц	175,286,716.80	188,661,916.80
39202	Хуримтлагдсан элэгдэл	(24,881,329.52)	(27,384,794.28)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	91,053,173.78	65,267,573.78
39204	Хуримтлагдсан элэгдэл	(40,412,357.40)	(11,628,514.80)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	175,697,820.19	103,510,489.44
39206	Хуримтлагдсан элэгдэл	(148,919,715.80)	(44,034,613.40)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	13,525,704.30	10,243,040.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,997,442.53)	(4,849,070.21)
39214	Бусад үндсэн хөрөнгө	82,132,003.96	75,482,388.49
39215	Хуримтлагдсан элэгдэл	(33,249,034.63)	(30,283,113.16)
393	Биет бус хөрөнгө	1,008,524,416.64	1,009,293,499.97
39301	Програм хангамж	2,580,000.00	1,430,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,408,583.36)	(489,500.03)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,008,353,000.00	1,008,353,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,325,975,711.46</u>	<u>2,359,630,932.44</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,325,975,711.46</u>	<u>2,359,630,932.44</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,325,975,711.46	2,359,630,932.44
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,343,813,362.55	1,343,813,362.55
51101	Өмч: - төрийн	1,343,813,362.55	1,343,813,362.55
512	Хуримтлагдсан үр дүн	933,913,006.96	988,098,115.67
51210	Өмнөх үеийн үр дүн	933,913,006.96	954,442,894.69
51220	Тайланг үеийн үр дүн	-	33,655,220.98
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	48,249,341.95	27,719,454.22
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,325,975,711.46</u>	<u>2,359,630,932.44</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,344,225,316.81	1,541,104,007.41
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	828,340,802.81	95,456,748.41
120	Нийтлэг татварын бус орлого	828,340,802.81	95,456,748.41
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	828,340,802.81	95,456,748.41
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,131,950.00	1,203,344.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	826,208,852.81	94,253,404.41
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,515,884,514.00	1,445,647,259.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,496,323,200.00	1,410,392,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,496,323,200.00	1,410,392,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	19,561,314.00	35,254,859.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,402,244.00	10,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,109,070.00	23,882,459.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,050,000.00	1,372,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,600,276,357.79	1,507,448,786.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,460,344,983.31	1,437,343,711.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,460,344,983.31	1,437,343,711.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,134,867,900.00	1,124,867,900.00
210101	Үндсэн цалин	807,810,000.00	819,541,700.00
210102	Нэмэгдэл	295,841,700.00	274,110,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	31,216,200.00	31,216,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	153,107,000.00	151,857,200.00
210201	Тэтгэврийн даатгал	107,712,400.00	106,862,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	11,348,600.00	11,248,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,079,000.00	8,998,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,269,600.00	2,249,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	22,697,400.00	22,497,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,650,365.52	43,519,501.00
210301	Гэрэл, цахилгаан	26,876,900.00	27,854,401.00
210302	Түлш, халаалт	14,958,455.50	14,791,900.00
210303	Цэвэр, бохир ус	815,010.02	873,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	35,447,646.59	25,813,786.14
210401	Бичиг хэрэг	1,386,490.00	952,960.00
210402	Тээвэр, шатахуун	10,688,087.00	12,123,632.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,259,037.00	1,722,014.00

Төв аймгийн Ус, Цаг уур орчны шинжилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,218,320.00	934,985.71
210408	Бараа материал акталсны зардал	15,655,712.59	9,896,194.43
2105	Нормативт зардал	132,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	132,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,264,760.00	23,120.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	133,250.00	00.00
210604	Урсгал засвар	4,131,510.00	23,120.00
2107	Томилолт, зочны зардал	5,963,940.00	3,224,460.00
210702	Дотоод албан томилолт	5,963,940.00	3,224,460.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	57,703,029.60	59,696,852.47
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	53,950,929.60	55,965,842.47
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	604,800.00	604,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	412,600.00	412,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	200,600.00	220,510.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	99,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	352,000.00	300,000.00
210807	Газрын төлбөр	2,094,100.00	2,094,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26,208,341.60	28,340,891.82
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	319,860.00	481,066.10
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	25,888,481.60	27,803,825.72
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	139,931,374.48	70,105,075.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	137,899,131.00	68,926,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	137,899,131.00	68,926,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,032,243.48	1,178,575.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,032,243.48	1,178,575.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	743,948,959.02	33,655,220.98
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	743,948,959.02	33,655,220.98

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,343,813,362.55	48,249,341.95	189,964,047.94	1,582,026,752.44
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,343,813,362.55	48,249,341.95	189,964,047.94	1,582,026,752.44
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайланг үеийн үр дүн	-	-	743,948,959.02	743,948,959.02
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,343,813,362.55	48,249,341.95	933,913,006.96	2,325,975,711.46
D01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	1,343,813,362.55	48,249,341.95	933,913,006.96	2,325,975,711.46
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	20,529,887.73	20,529,887.73
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,343,813,362.55	48,249,341.95	954,442,894.69	2,346,505,599.19
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(20,529,887.73)	-	(20,529,887.73)
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайланг үеийн үр дүн	-	-	33,655,220.98	33,655,220.98
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,343,813,362.55	27,719,454.22	988,098,115.67	2,359,630,932.44

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,518,016,464.00	1,446,610,603.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,131,950.00	963,344.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,131,950.00	963,344.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,131,950.00	963,344.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,131,950.00	963,344.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,515,884,514.00	1,445,647,259.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,496,323,200.00	1,410,392,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,496,323,200.00	1,410,392,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	19,561,314.00	35,254,859.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,гүүнгэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,402,244.00	10,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,109,070.00	23,882,459.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,050,000.00	1,372,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,518,016,464.00	1,425,555,803.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,518,016,464.00	1,425,555,803.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,378,085,089.52	1,355,450,728.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,134,867,900.00	1,124,867,900.00
210101	Үндсэн цалин	807,810,000.00	819,541,700.00
210102	Нэмэгдэл	295,841,700.00	274,110,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	31,216,200.00	31,216,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	153,107,000.00	151,857,200.00
210201	Тэтгэврийн даатгал	107,712,400.00	106,862,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	11,348,600.00	11,248,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,079,000.00	8,998,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,269,600.00	2,249,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	22,697,400.00	22,497,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,650,365.52	43,519,501.00
210301	Гэрэл, цахилгаан	26,876,900.00	27,854,401.00
210302	Түлш, халаалт	14,958,455.50	14,791,900.00
210303	Цэвэр, бохир ус	815,010.02	873,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,856,384.00	14,137,861.00
210401	Бичиг хэрэг	1,145,900.00	1,070,159.00
210402	Тээвэр, шатахуун	12,603,087.00	9,615,802.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,259,037.00	2,100,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,608,360.00	1,111,700.00

Төв аймгийн Ус, Цаг уур орчны шинжилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2105	Нормативт зардал	332,000.00	332,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	332,000.00	332,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,233,640.00	339,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,614,400.00	166,400.00
210604	Урсгал засвар	5,619,240.00	172,800.00
2107	Томилолт, зочны зардал	5,963,940.00	3,224,460.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,584,800.00	16,694,747.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,832,700.00	12,963,737.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	604,800.00	604,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	412,600.00	412,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	200,600.00	220,510.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	99,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	352,000.00	300,000.00
210807	Газрын төлбөр	2,094,100.00	2,094,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	489,060.00	477,859.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	489,060.00	477,859.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	139,931,374.48	70,105,075.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	137,899,131.00	68,926,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	137,899,131.00	68,926,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,032,243.48	1,178,575.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,032,243.48	1,178,575.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	21,054,800.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	21,054,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	21,054,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	21,054,800.00
225102	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	-	21,054,800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(21,054,800.00)

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,410,492,400.00	1,410,177,169.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,410,492,400.00	1,410,177,169.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,341,250,900.00	1,341,250,669.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,124,867,900.00	1,124,867,900.00
210101	Үндсэн цалин	819,541,700.00	819,541,700.00
210102	Нэмэгдэл	274,110,000.00	274,110,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	31,216,200.00	31,216,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	151,857,200.00	151,857,200.00
210201	Тэтгэврийн даатгал	106,862,500.00	106,862,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	11,248,700.00	11,248,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,998,900.00	8,998,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,249,700.00	2,249,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	22,497,400.00	22,497,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,213,800.00	41,213,800.00
210301	Гэрэл, цахилгаан	25,548,700.00	25,548,700.00
210302	Түлш, халаалт	14,791,900.00	14,791,900.00
210303	Цэвэр, бохир ус	873,200.00	873,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,978,500.00	6,978,500.00
210401	Бичиг хэрэг	770,200.00	770,200.00
210402	Тээвэр, шатахуун	3,848,900.00	3,848,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,200,200.00	1,200,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хоргон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	919,200.00	919,200.00
2105	Нормативт зардал	332,000.00	332,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	332,000.00	332,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	904,300.00	904,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	731,500.00	731,500.00
210604	Урсгал засвар	172,800.00	172,800.00
2107	Томилолт, зочны зардал	2,568,400.00	2,568,400.00
210702	Дотоод албан томилолт	2,568,400.00	2,568,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,050,800.00	12,050,710.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,319,700.00	8,319,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	604,800.00	604,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	412,600.00	412,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	220,600.00	220,510.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000.00	99,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	300,000.00	300,000.00
210807	Газрын төлбөр	2,094,100.00	2,094,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	478,000.00	477,859.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	478,000.00	477,859.00

Төв аймгийн Ус, Цаг уур орчны шинжилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	69,241,500.00	68,926,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	69,241,500.00	68,926,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	69,241,500.00	68,926,500.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,410,492,400.00	1,410,492,400.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,410,392,400.00	1,410,392,400.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,410,392,400.00	1,410,392,400.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	100,000.00	963,344.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	100,000.00	963,344.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	98.00	98.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	90.00	90.00
620003	Үйлчлэх ажилтан	7.00	7.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	35,254,859.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	35,254,859.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	35,254,859.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,305,701.00
210301	Гэрэл, цахилгаан	2,305,701.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,159,361.00
210401	Бичиг хэрэг	299,959.00
210402	Тээвэр, шатахуун	5,766,902.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	900,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	192,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,000,000.00
210604	Урсгал засвар	20,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	656,060.00
210702	Дотоод албан томилолт	656,060.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,133,737.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,133,737.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	35,254,859.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	35,254,859.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,882,459.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,372,400.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Ус, Цаг уур орчны шинжилгээний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн төлөвлөлт, худалдан авалттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Хүрэлбаатар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Ус, Цаг уур орчны шинжилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 01/05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Ус, Цаг уур орчны шинжилгээний төв нь Ус, цаг агаарын урьдчилсан болон сэрэмжлүүлэх мэдээ, байгаль орчны мэдээ мэдээллээр нийгмийн хэрэгцээг хангах, байгаль цаг агаарын болзошгүй аюул, орчны ноцтой бохирдлоос урьдчилан сэргийлэх зорилго бүхий байгууллага юм.

Төв аймгийн Ус, Цаг уур орчны шинжилгээний төвийн тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төв аймгийн Ус, Цаг уур орчны шинжилгээний төвийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Ус, Цаг уур орчны шинжилгээний төвийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Ус, Цаг уур орчны шинжилгээний төвийн даргын 2020 оны А/14 тоот тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй дотоод хяналт шалгалт явуулах ажлын хэсгийг байгуулж шалгалт явуулах хуваарийг баталсан байна.

Дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгасан үйл ажиллагаануудаас байгууллагын төсөв, санхүүтэй холбоотой 5 ажил, шилэн данстай холбоотой хяналт шалгалтыг хийсэн байна. Тайлант онд аймгийн Санхүүгийн хяналт аудитын албанаас хяналт, шалгалт хийгдээгүй байна.

Төв аймгийн Ус, Цаг уур орчны шинжилгээний төвийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Ус, Цаг уур орчны шинжилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт орлогын 1,446,610.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 21,699.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 17,359.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Төв аймгийн Ус, Цаг уур орчны шинжилгээний төвийн төлөвлөх үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн мэдээллээр тооцсон тул гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогоос дахин тооцлоо.

Гүйцэтгэлийн үе шатанд шинэчлэн тогтоосон материаллаг байдлын түвшин 23,112.9 мянган төгрөг, энэ нь төлөвлөлтийн үе шатнаас 1,413.8 мянган төгрөгөөр өссөн байна. Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 18,490.3 мянган төгрөгөөр тогтоогдсон байна.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Энэхүү Санхүүгийн тайлангаар Төв аймгийн Ус, Цаг уур орчны шинжилгээний төвийн 2021 оны санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнг толилуулж байна. Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 4.4 дэх заалтыг үндэслэн Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

(УСНББОУС) болон Монгол Улсын холбогдох хууль, журам, заавар, Цаг уур, орчны шинжилгээний салбарт мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн санхүүгийн тайланг бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартад шаардсан зарчмын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар бэлтгэн тайлагнасан байна.

Орлого:

Тус байгууллага 2021 онд улсын төсвөөс 1,410,392.4 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 2,335.7 мянган төгрөг, Ус цаг уур орчны шинжилгээний газраас 23,882.4 мянган төгрөг, аймгийн төсвөөс 10,000.0 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 94,253.4 мянган төгрөг нийт 1,540,864.0 мянган төгрөг, өмнөх оноос 803,361.3 мянган төгрөгөөр буюу 34 хувиар буурсан байна. Энэ нь үнэ төлбөргүй орлоготой холбоотой байна.

Зардал:

Төв аймгийн Ус, Цаг уур орчны шинжилгээний төв нь 2021 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангаар 1,507,448.7 мянган төгрөг, мөнгөн гүйлгээний тайлангаар 1,425,555.8 мянган төгрөг, төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 1,445,432.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө:

Тус байгууллага төрийн сангийн 100140013015 тоот дансанд 2021 онд 1,425,065.0 мянган төгрөгийн орлого, 1,425,065.0 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж, 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл 0 төгрөг байна. Мөн нэмэлт санхүүжилтийн 100140013401 тоот дансанд 36,054.4 мянган төгрөгийн орлого төвлөрч, 36,054.4 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж үлдэгдэл 0 төгрөг байна. *Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мян.төгрөг/ Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	0	240.0	240.0
Урьдчилгаа			
Бараа материал	1,038,215.7	1,025,112.1	-13,103.6
Үндсэн хөрөнгө	1,287,759.9	1,334,278.8	46,518.8
Нийт хөрөнгө	2,325,975.7	2,359,630.9	33,655.2
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,325,975.7	2,359,630.9	33,415.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,325,975.7	2,359,630.9	33,415.2

Авлага дансны үлдэгдэл 240.0 мянган төгрөг болж өссөн нь Төв АЗЗА ТӨХК-нд үйлчилгээ үзүүлсний орлого дараа онд орсонтой холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 1,025,112.1 мянган төгрөг болж 13,103.6 мянган төгрөгөөр буурсан нь бараа материал акталснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,334,278.8 мянган төгрөг болж 46,518.8 мянган төгрөгөөр өссөн нь хөрөнгийн өсөлттэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 21,054.8 мянган төгрөг, үнэ төлбөргүй шилжиж ирсэн 6,145.4 мянган төгрөг, дахин үнэлсэн 48,003.1 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, акталсан 13,225.8 мянган төгрөг, шилжүүлсэн 9,336.3 мянган төгрөг, дахин үнэлгээний хорогдол 148,321.1 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,359,630.9 мянган төгрөг болж 33,415.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,174,247.4 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний нийт зарлагыг 2,078,435.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 763,755.0 мянган төгрөгөөр бууруулж улсын төсвөөс 1,410,392.4 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 100.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна. Энэ нь байр ашиглахтай холбоотой зардал, хангамж бараа материалын зардал, нормативт зардал, эд хогшил урсгал засварын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг бууруулсантай холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,410,392.4 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,410,392.4 мянган төгрөгийг улсын төсвөөс 100.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,410,392.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагааны орлого 963.3 мянган төгрөг нийт 1,411,355.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,410,177.1 мянган төгрөгийг зарцуулж, 315.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,410,177.1 мянган төгрөг буюу 99,98 хувьтай байгаа нь нэг удаагийн тэтгэмжийн зарцуулаагүй үлдэгдэлтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн

гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Ус, Цаг уур орчны шинжилгээний төв тайлант онд Ус, Цаг уур орчны шинжилгээний газраас 23,882.4 мянган төгрөг, Аймгийн Засаг даргын нөөцөөс 10,000.0 мянган төгрөг, өөрийн орлого 1,372.4 мянган төгрөг нийт 35,254.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Үүнээс хангамж бараа материалын зардалд байр ашиглалттай холбоотой зардалд 2,305.7 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардалд 7,159.3 мянган төгрөг, урсгал зардалд 20,000.0 мянган төгрөг, томилолтын зардалд 656.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 5,133.7 мянган төгрөг, нийт 35,254.8 мянган төгрөгийг зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төв аймгийн Ус, Цаг уур орчны шинжилгээний төв нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 508 дугаар тогтоолоор 148,321.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдсаны гарз гэж дахин үнэлгээг хорогдуулан 48,003.1 мянган төгрөгөөр 1-7 жилийн хугацаатайгаар ашиглах жилийн хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоосон байна.

2021 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Жаргалант, Мөнгөнморьт сумдын цаг уурын өртөөний барилгад их засвар хийж, хөрөнгийн сайжруулалтыг данс бүртгэлд тусгасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Төв аймгийн Ус, Цаг уур орчны шинжилгээний төв нь Орчны чанарын хяналт шинжилгээний ажил, үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулахдаа томилолт, унааны зардлыг төсвийн бус дансанд авахаар тусгадаг, байгуулсан гэрээг дүгнэдэггүй, орлогыг гэрээний гүйцэтгэлд үндэслэн аккруэл сууриар хүлээн зөвшөөрч бүртгээгүй байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд зарцуулах эрхийг нээлгэхдээ зарцуулагдах зардлын зүйл тус бүр дээр эрхээ нээлгэхгүй, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардал дээр бөөн дүнгээр эрхээ нээлгэснээр зориулалт бусаар зарцуулсан зардлын хэмжээ ихсэж байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор

www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 132 мэдээллээс хугацаандаа оруулсан 130 мэдээлэл, хугацаа хоцроосон 2 мэдээлэл байна. Тус байгууллага 5,0 саяас дээших орлогын 15, зарлагын 25 гүйлгээ байршуулж, 5,0 саяас дээших худалдан авалтын 83 гүйлгээ байршуулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлангийн аудитад шаардлагатай баримт, материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, нэмэлт санхүүжилтээр зарцуулсан хөрөнгө, үнэ төлбөргүй хүлээн авсан орлогууд бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тус байгууллага 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар туслах үйл ажиллагааны төлөвлөлт, худалдан авалтыг и-баримтаар баталгаажуулахтай холбоотой 2 зөвлөмж өгөгдсөн байна. Хэрэгжилтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 01/105 тоот албан бичгээр гарган ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Орлогын бүртгэл, гэрээ, гэрээний хэрэгжилт, авлагын талаар дараагийн аудитаар анхаарах.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 20,275.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 7,916.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 2,135.2 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч, 10,223.8 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага бичив.

4.1 Залруулсан алдаа

Тус байгууллага өмнөх оны үр дүнгийн тайланд нэмэлт санхүүжилтийн орлогыг 2,350.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан, Төв АЗЗА-тай гэрээ байгуулж, үйлчилгээ үзүүлсний төлбөр 240.0 төгрөгийг авлагаар тусгаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Үндсэн хөрөнгийн данс дахь 5,326.8 мянган төгрөгийн 4 ширхэг үндсэн хөрөнгөнд элэгдэл бодоогүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

4.3 Албан шаардлага

Төсвөөс зориулалт бусаар 866.4 мянган төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалт, “Үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Тус байгууллагын нягтлан бодогч, архив бичиг хэргийн ажилтнууд нь Албан тушаалын тодорхойлолтод заасан ажил үүргийг гүйцэтгэж байгаа боловч ажил хавсарсан нэмэгдэл 6,254.7 мянган төгрөг авсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалт, “Үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалтыг /дансны хуулгын дүнг/ Татварын Е баримт, Е постын дүнтэй тулгалт хийхэд Е баримтын дүн шилжүүлсэн мөнгөн дүнгээс 3,102.5 мянган төгрөгөөр дутуу байна. Энэ нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Орчны чанарын хяналт шинжилгээний ажил, үйлчилгээний орлогыг гэрээний гүйцэтгэлд үндэслэн аккруэл сууриар хүлээн зөвшөөрч бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө”, 20 дугаар

зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

- Цаашид орчны хяналт шинжилгээний ажил үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулж, гэрээг дүгнэсний үндсэн дээр орлогыг хүлээн зөвшөөрч бүртгэж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Төв аймгийн УЦУОШТөв	6	20,275.8	2	7,916.8	0	0	3	10,223.8	1	2,135.2